

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2023/133/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a>
Чойбалсан хот 2023 он	Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: <a href="mailto:narmandakh@audit.gov.mn">narmandakh@audit.gov.mn</a>
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Ари файнэнс аудит” ХХК Утас: 99088151 Цахим хаяг: <a href="mailto:arifin.audit@gmail.com">arifin.audit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.04.24 № 221

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ХЭРЛЭН СУМЫН ХАН-УУЛ ЦОГЦОЛБОР Т  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЦОГЗОЛМАА  
ТАНАА

### Г Өөрчлөлтгүй дүгнэлт Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Хан-уул цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын Хан-уул цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

#### Бусад асуудлын хэсэг

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд, холбоо барих

011020216

мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>261,628,398.21</b>	<b>315,440,407.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>68,952,019.70</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>68,952,019.70</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	<b>68,952,019.70</b>
31211	Төрийн сангийн харилцах	-	68,952,019.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>261,628,398.21</b>	<b>246,488,387.41</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>46,373,047.34</b>	<b>51,857,352.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	46,373,047.34	51,857,352.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>215,255,350.87</b>	<b>194,631,035.41</b>
35460	Хүнсний материал	-	121,550.00
35470	Бусад хангамжийн материал	213,968,312.87	194,509,485.41
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,165,261,192.05</b>	<b>7,119,034,865.62</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,165,261,192.05</b>	<b>7,119,034,865.62</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,512,590,192.05</b>	<b>5,466,363,865.62</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,380,459,781.43	5,380,459,781.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(136,914,332.73)	(236,438,423.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,995,000.00	49,995,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,019,531.25)	(19,268,906.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	436,249,411.94	456,647,552.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	(363,901,390.36)	(338,731,272.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	257,279,745.64	269,716,545.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111,583,492.62)	(136,739,812.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,700,000.00	44,004,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(675,000.00)	(3,280,600.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,652,671,000.00</b>	<b>1,652,671,000.00</b>
39301	Програм хангамж	815,000.00	815,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(815,000.00)	(815,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,652,671,000.00	1,652,671,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,426,889,590.26</b>	<b>7,434,475,272.73</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,426,889,590.26</b>	<b>7,434,475,272.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,426,889,590.26</b>	<b>7,434,475,272.73</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,344,691,476.38	2,344,691,476.38
51101	Өмч: - төрийн	2,344,691,476.38	2,344,691,476.38
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,764,520,097.45</b>	<b>2,772,105,779.92</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,764,520,097.45	(4,662,369,492.81)
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,434,475,272.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,317,678,016.43	2,317,678,016.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,426,889,590.26</b>	<b>7,434,475,272.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,719,352,349.01</b>	<b>10,763,022,853.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,492,710,235.01</b>	<b>7,503,998,099.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>108,161,935.01</b>	<b>7,503,998,099.26</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>108,161,935.01</b>	<b>10,245,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,695,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,550,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,219,125,702.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	274,626,597.21
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>2,384,548,300.00</b>	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2,384,548,300.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>226,642,114.00</b>	<b>3,259,024,754.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	<b>2,942,630,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,942,630,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>153,135,714.00</b>	<b>88,721,054.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153,135,714.00	88,721,054.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>73,506,400.00</b>	<b>227,673,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,506,400.00	227,673,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,715,303,312.27</b>	<b>3,328,547,580.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,715,303,312.27</b>	<b>3,328,547,580.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,505,104,020.71</b>	<b>3,070,549,413.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,912,763,144.55</b>	<b>2,330,175,267.98</b>
210101	Үндсэн цалин	1,912,763,144.55	1,909,855,243.98
210102	Нэмэгдэл	-	374,651,294.00
210104	Урамшуулал	-	45,668,730.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>249,932,123.00</b>	<b>198,333,015.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	176,478,865.20	141,762,260.43
210202	Тэтгэмжийн даатгал	19,195,555.22	14,281,271.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,716,730.06	11,384,917.28
210204	Ажилгүйдлийн даатгал	3,577,312.48	2,817,890.98
210205	Эрүүл мэндийн даатгал	35,963,660.04	28,086,675.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>98,343,919.89</b>	<b>114,279,771.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,573,437.89	39,847,416.41
210302	Түлш, халаалт	64,260,110.00	54,185,513.14
210303	Цэвэр, бохир ус	11,510,372.00	20,246,842.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>101,674,384.96</b>	<b>7,513,894.35</b>

**Хэрлэн сумын Ерөнхий боловсролын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210401	Бичиг хэрэг	5,761,500.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,200.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,375,810.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,605,425.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	
210408	Бараа материал акталсны зардал	74,165,749.96	7,513,894.35
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,880,200.00</b>	<b>98,069,551.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,229,600.00	
210502	Хоол, хүнс	39,340,000.00	98,069,551.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,310,600.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>597,300.00</b>
210604	Урсгал засвар	4,000,000.00	597,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,792,600.00</b>	<b>9,421,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,792,600.00	451,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,970,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>81,717,648.31</b>	<b>312,159,213.19</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	152,874,496.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,546,000.00	7,051,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,171,648.31	152,232,836.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>210,199,291.56</b>	<b>257,998,167.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>173,009,679.00</b>	<b>252,504,589.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,149,800.00	163,783,535.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,761,145.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,598,734.00	88,721,054.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>37,189,612.56</b>	<b>5,493,578.45</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,189,612.56	5,493,578.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,049,036.74</b>	<b>7,434,475,272.73</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>4,049,036.74</b>	<b>7,434,475,272.73</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,611,190,414.00</u>	<u>3,269,270,554.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,384,548,300.00	10,245,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,245,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,245,800.00

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,695,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,550,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,384,548,300.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	2,384,548,300.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>226,642,114.00</b>	<b>3,259,024,754.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	<b>2,942,630,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,942,630,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>153,135,714.00</b>	<b>88,721,054.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153,135,714.00	88,721,054.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>73,506,400.00</b>	<b>227,673,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,506,400.00	227,673,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,611,190,414.00</b>	<b>3,148,176,534.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,611,190,414.00</b>	<b>3,148,176,534.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,400,991,122.44</b>	<b>2,863,415,486.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,912,763,144.55</b>	<b>2,247,718,954.00</b>
210101	Үндсэн цалин	1,121,784,405.00	1,467,566,891.00
210102	Нэмэгдэл	680,507,986.55	670,010,668.00
210104	Урамшуулал	110,470,753.00	109,666,139.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	475,256.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>249,932,123.00</b>	<b>280,355,929.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	176,478,865.20	191,168,890.49
210202	Тэтгэмжийн даатгал	19,195,555.22	22,490,260.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,716,730.06	17,945,408.43
210204	Ажилгүйдлийн даатгал	3,577,312.48	4,440,020.74
210205	Эрүүл мэндийн даатгал	35,963,660.04	44,311,349.25
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>98,343,919.89</b>	<b>119,237,771.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,573,437.89	33,154,014.09
210302	Түлш, халаалт	64,260,110.00	65,836,915.46
210303	Цэвэр, бохир ус	11,510,372.00	20,246,842.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,637,135.00</b>	
210401	Бичиг хэрэг	7,288,925.00	
210402	Тээвэр, шатахуун	2,499,700.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,266,200.00	
210404	Ном, хэвлэл	2,518,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,375,810.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,688,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>50,880,200.00</b>	<b>71,428,221.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,229,600.00	
210502	Хоол, хүнс	39,340,000.00	71,428,221.00
<b>210503</b>	<b>Нормын хувцас, зөөлөн эдлэл</b>	<b>10,310,600.00</b>	

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,653,000.00</b>	<b>6,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,653,000.00	
210604	Урсгал засвар	4,000,000.00	6,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,792,600.00</b>	<b>26,558,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,792,600.00	7,211,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	19,346,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,989,000.00</b>	<b>112,116,511.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,443,000.00	83,101,511.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,546,000.00	29,015,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>210,199,291.56</b>	<b>284,761,047.45</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>173,009,679.00</b>	<b>279,267,469.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,149,800.00	190,546,415.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,761,145.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,598,734.00	88,721,054.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>37,189,612.56</b>	<b>5,493,578.45</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,189,612.56	5,493,578.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>=</b>	<b><u>121,094,019.70</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>52,142,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>52,142,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>52,142,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	52,142,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>=</b>	<b><u>(52,142,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>68,952,019.70</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	68,952,019.70

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,344,691,476.38	2,317,678,016.43	4,662,369,492.81	

Хэрлэн сумын Ерөнхий боловсролын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,344,691,476.38	2,317,678,016.43	4,662,369,492.81	
Тайлант үеийн үр дүн			7,434,475,272.73	<b>7,434,475,272.73</b>
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>2,344,691,476.38</b>	<b>2,317,678,016.43</b>	<b>2,772,105,779.92</b>	<b>7,434,475,272.73</b>

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,180,333,700.00</b>	<b>3,106,103,901.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,180,333,700.00</b>	<b>3,106,103,901.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,970,908,421.55</b>	<b>2,915,557,486.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,269,410,972.00</b>	<b>2,247,718,954.00</b>
210101	Үндсэн цалин	1,771,114,019.00	1,467,566,891.00
210102	Нэмэгдэл	442,214,556.00	670,010,668.00
210104	Урамшуулал	56,082,397.00	109,666,139.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>296,700,478.00</b>	<b>280,355,929.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	202,010,040.78	191,168,890.49
210202	Тэтгэмжийн даатгал	23,765,873.55	22,490,260.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,985,838.77	17,945,408.43
210204	Ажилгүйдлийн даатгал	4,730,468.24	4,440,020.74
210205	Эрүүл мэндийн даатгал	47,208,256.66	44,311,349.25
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>119,237,771.55</b>	<b>119,237,771.55</b>
210301	Гэрэл, цахилгаан	33,154,014.09	33,154,014.09
210302	Түлш, халаалт	65,836,915.46	65,836,915.46
210303	Цэвэр, бохир ус	20,246,842.00	20,246,842.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>87,538,600.00</b>	<b>71,428,221.00</b>
210502	Хоол, хүнс	87,538,600.00	71,428,221.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>6,000,000.00</b>
210604	Урсгал засвар	11,493,578.45	6,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,826,900.00</b>	<b>26,558,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,480,000.00	7,211,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,346,900.00	19,346,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>165,193,700.00</b>	<b>164,258,511.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,173,400.00	135,243,511.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,020,300.00	29,015,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>209,425,278.45</b>	<b>190,546,415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>203,931,700.00</b>	<b>190,546,415.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	203,931,700.00	190,546,415.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,180,333,700.00</b>	<b>3,175,055,921.55</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,942,630,100.00</b>	<b>2,942,630,100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,942,630,100.00	2,942,630,100.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,030,000.00</b>	<b>10,245,800.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,480,000.00	7,695,800.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	2,550,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>227,673,600.00</b>	<b>222,180,021.55</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	227,673,600.00	222,180,021.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,952,019.70

**2.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>88,721,054.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>88,721,054.00</b>
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>88,721,054.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>88,721,054.00</b>
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	88,721,054.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>88,721,054.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>88,721,054.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,721,054.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4 алдаа зөрчил<sup>1</sup> илэрснээр, 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Албан шаардлага

##### 1. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

##### 2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгэн бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

## 2. Тооллого, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	-			1			-
Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1						1	
Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	1	-					1	-
Түрээсийн номноос орсон орлогыг аккурэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу илэрхийлсэн байх, нотлох баримтгүй, тайлан тооцоо гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил гаргаж бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 30 мэдээллүүдийг мэдээлээгүй байна.	1	524,788.5			1	524,788.5		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>524,788.5</b>			<b>1</b>	<b>524,788.5</b>		



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/01 ДДН-2023/133/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн "Хан-Уул" цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байр ашиглалттай холбоотой зардлын бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн захирал Ч.Цогзолмаа, нягтлан бодогч П.Урантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ

Д.АРИУНАА



011040407



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 80/02 ДООА-2023/133/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын Хан-уул цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 524,788,518.00 /таван зуун хорин дөрвөн сая долоон зуун наян найман мянга таван зуун арван найм/ төгрөгийн 30 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулахад тавих дотоод хяналтыг сайжруулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын "Хан-Уул" цогцолбор сургуулийн захирал Ч.Цогзолмаа, нягтлан бодогч П.Урантуяа нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Д.АРИУНАА

011040440



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 8/03 ДОА-2023/133/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын “Хан-Уул” цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040443

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургуулийн захирал Ч.Цогзолмаа, нягтлан бодогч П.Урантуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР

  
И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

  
Д.АРИУНАА